

“НЭГЖ ХИЧЭЭЛ” ХЭМЭЭХ НЭГЭН ЗҮЙЛ ТӨӨРӨГДЛИЙН ТУХАЙД

Ц.Баасандорж, профессор, НХУС

Аннотация. В настоящее время учителя наших общеобразовательных школ фронтально охвачены неким заблуждением под названием “урок-единица”, впоследствии чего они вынуждены ежедневно осуществлять так называемую “Программу урока-единицы”, которая является никому непонятной и ненужной выдумкой.

Документом, который нужно составлять и реализовывать для того, чтобы обеспечивать нормальный учебный процесс и, тем самым, повышать его качество и эффективность, немедленно избавившись от данного заблуждения, является тематический план, а также план очередного урока. Данные планы есть и методические материалы для обучения, и документ, который обязательно должен составлять учитель, и результаты творческой работы учителя.

Түлхүүр үг: Сэдэвчилсэн төлөвлөгөө, ээлжит хичээлийн төлөвлөгөө, нэгж ажил, нэгж хичээл, нэгж хичээлийн төлөвлөгөө, төөрөгдөл.

Бид энэ удаа ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалттай холбоотой хийж хэрэглэж ирсэн болон эдүгээ хийж хэрэглэж байгаа бичиг баримтын талаар өөрсдийн санал, байр суурийг хуваалцахыг зорилгоо.

Бидний багтай мэдэхээр 1981 онд Ардын Боловсролын Яамны сайдын 305 дугаар тушаалаар “Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө зохиох, конспект хийх, тэдгээрийг дахин хэрэглэх үлгэрчилсэн заавар” батлагдан гарсан билээ. Ингэснээр ерөнхий боловсролын сургуулийн багш нар 1981 оноос 1987 оныг дуустал дээрх зааврыг баримтлан хэрэгжүүлж ирсэн юм. Өөрөөр хэлбэл 1981 оноос манай ерөнхий боловсролын сургуулийн багш нар сургалттай холбоотой I. Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө, II. Конспект гэсэн үндсэн хоёр баримт бичиг боловсруулан тэдгээрийг жилээс жилд засан сайжруулах замаар хэрэглэж ирсэн билээ.

1987 онд АБЯ-ны сайдын 358 дугаар тушаал гарсан болно. Уг тушаалаар дээр өгүүлсэн ерөнхий боловсролын сургуулийн багш нар 1981 оноос баримтлан хэрэгжүүлж ирсэн “Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө зохиох, конспект хийх, тэдгээрийг дахин хэрэглэх үлгэрчилсэн заавар” нь багшийн үйл ажиллагааг зарим талаар боогдуулж байсныг тэмдэглэн буруушааж 1981 оны 305 дугаар тушаалыг хүчингүй болгожээ. (Ерөнхий боловсролын сургуулийн., 1988. т. 9)

Улмаар 1987 оны АБЯ-ны сайдын 358 дугаар тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн нийт багш, техник мэргэжлийн сургуулийн ерөнхий эрдмийн хичээлийн багш нар өөрийн

заах хичээлийн сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөөг заавал хийх, тэгэхдээ нэг хэлбэр загвараар биш, өөрийн үйл ажиллагаанд тус болохуйц байдлаар бүтээлчээр хийж хэрэглэж байх нь зүйтэй” гэж үзэж “Ерөнхий боловсролын сургуулийн багш нараас сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө хийх зөвлөмж”-ийг баталсан юм.

Энэ зөвлөмжид “Багш бүрийн заавал хийж мөрдөх бичиг баримтад сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө (конспект) багтана” гэж заасан. Ийнхүү 1988 оноос АБЯ-ны сайдын 358 дугаар тушаалын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн багш нар өөрийн заах хичээлийн сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөөг заавал хийх, тэгэхдээ нэг хэлбэр загвараар биш, өөрийн үйл ажиллагаанд тус болохуйц байдлаар бүтээлчээр хийж хэрэглэж байхаар болсон. Өөрөөр хэлбэл 1981 оноос хойш хийж хэрэглэж ирсэн “Сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө” гэсэн үндсэн хоёр баримт бичгээ нэг хэлбэр загвараар биш, өөрийн үйл ажиллагаанд тус болохуйц байдлаар бүтээлчээр хийж хэрэглэж байхаар болсон.

Уг зөвлөмжид эдүгээ ч үнэ цэнээ алдаагүй хэдэн зүйл буйг онцлон тэмдэглэе. Үүнд:

1. Программын агуулгын дагуу сурагчдыг сургах, хүмүүжүүлэх, хөгжүүлэх зорилгоор хичээлийн бүлэг сэдвийг хичээл нэг бүрээр хуваарилсан албан баримт бичгийг хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө гэнэ.
2. Ээлжит хичээлийн төлөвлөгөө (конспект) нь хичээлийн зорилго, зохион байгуулалт, арга

барил, хэлбэрийг тусгасан багшаас тухайн хичээлийг удирдан явуулах удирдамж материал болно.

3. Сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө нь аргазүйн материал, багшийн хөтлөх баримт бичиг, бүтээл бөгөөд тухайн багшийн заасан хичээлийн цагийг тооцох санхүүгийн баримт биш юм. (Ерөнхий боловсролын сургуулийн, 1988. т. 9)

Ийнхүү 1981 оноос 2000-аад оны төгсгөл хүртэл АБЯ-ны сайдын 305, 358-р тушаалын дагуу манай ерөнхий боловсролын сургуулийн багш нар сургалттай холбоотой 1. Сэдэвчилсэн төлөвлөгөө, 2. Ээлжит хичээлийн төлөвлөгөө гэсэн үндсэн хоёр баримт бичгийг боловсруулан хэрэглэж ирсэн. Эдгээр баримт бичгүүд нь нэг талаас сургалтад зайлшгүй хэрэгтэй, нөгөө талаас ойлгомжтой баримт бичгүүд байлаа.

Эдгээрийг заавал, гэхдээ нэг хэлбэр загвараар биш, өөрийн үйл ажиллагаанд тус болохуйц байдлаар бүтээлчээр хийж хэрэглэж байх тухай дээр өгүүлсэн 1987 оны 358 дугаар тушаал эдүгээ ч хүчинтэй хэвээр буй болов уу. Уг тушаалыг хүчингүй болгосон эрх зүйн актыг олж үзсэнгүй.

Иймээс эдүгээ ч манай ерөнхий боловсролын дунд сургуулийн багш нараас хичээл сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах, улмаар чанар, үр өгөөжийг нь дээшлүүлэх зорилгоор заавал хийж хэрэгжүүлэх ёстой баримт бичиг бол Сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө юм. Энэхүү төлөвлөгөөнүүд нь өмнө өгүүлснээр сургалтад зориулсан арга зүйн материал, багшийн хөтлөх баримт бичиг, бүтээл билээ.

Гэтэл 2000-аад оны төгсгөлөөр, тухайлбал 2008, 2009 оны үеэс багшийн ажлын норм тогтоох, цалин хөлсийг тооцож олгохтой холбогдон гарч ирсэн сургалтын нэгж ажил хэмээх багшийн ажлыг хэмжих нэгжийг багшийн сургалтад зориулан хийдэг арга зүйн материал, хөтлөх баримт бичиг хэмээн эндүү ойлгон “Нэгж хичээлийн хөтөлбөр” хэмээх зохиомол баримт бичгийг багш нарын авдаг цалин хөлстэй холбож, захиргааны аргаар хийлгэж эхэлсэн. Үүний улмаас манай ерөнхий боловсролын дунд сургуулийн багш нар “Нэгж хичээл” хэмээх нэгэн зүйл төөрөгдөлд орсон.

Ингэснээр эдүгээ өөрсдийн 30-аад жилийн турш хийж хэрэглэж ирсэн сэдэвчилсэн болон ээлжит хичээлийн төлөвлөгөөгөө мартаж, оронд нь огт ойлгомжгүй боловч цалин хөлсөө авахын тулд аргагүйн эрхэнд хийдэг, хэрэглээгүй бөгөөд хэрэглэх боломж ч үгүй “Бүлэг сэдвийн тогтолцоо”, “Нэгж хичээлийн хөтөлбөр” гэсэн зүйлс хийдэг болжээ.

Энэ төөрөгдөл 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдөр БСШУ-ны сайд, НХХ-ийн сайд, Сангийн сайдын хамтарсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам батлах тухай” 307/91/237 дугаар тушаалаас үүдэлтэй аж.

Уг тушаалын хавсралтаар батлагдсан “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцож олгох журам”-ын 2.14-д “Бага дунд боловсролын стандартад нийцүүлэн сургалтын төлөвлөгөөний дагуу хөтөлбөрөө төлөвлөн боловсруулах, уг хөтөлбөрөөр хичээл заах, түүнийгээ үнэлж сайжруулах цогц үйл ажиллагааг илэрхийлэх стандартыг хэрэгжүүлэх Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг сургалтын нэгж ажлаар хэмжинэ. Энэхүү нэгж ажил нь сургалтын төлөвлөгөөний 5 цагаар тооцогдоно. Сургалтын нэгж ажлыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан Философи, эрх зүйн боловсрол, 2014, №8 дагуу тооцож үзнэ” (Боловсролын салбарын эрх зүйн, 2012, т. 33) гэжээ.

Уг хамтарсан тушаалд анх удаа “Сургалтын нэгж ажил” гэсэн шинэ нэр томьёо хэрэглэжээ. Эндээс юуны өмнө “Сургалтын нэгж ажил” гэж юу вэ? гэдгийг зөв ойлгон хэрэгжүүлэх шаардлага тулгарсан байна. Энэ шаардлагын дагуу “Сургалтын нэгж ажил” гэж юу вэ? гэдгийг ахин дахин эргэцүүлвээс:

Тушаалд өгүүлснээр “Сургалтын нэгж ажил” гэдэг нь Ерөнхий боловсролын сургуулийн багшийн стандартыг хэрэгжүүлэх ажлыг хэмжих хэмжүүр юм. Стандартыг хэрэгжүүлэх ажилд хөтөлбөрөө төлөвлөн боловсруулах, уг хөтөлбөрөөр хичээл заах, түүнийгээ үнэлж сайжруулах цогц үйл ажиллагаа багтана. Энэхүү нэгж ажил нь сургалтын төлөвлөгөөний 5 цагаар тооцогдоно гэжээ.

Эндээс “Сургалтын нэгж ажил” гэдэг нь 5 цагийн хөтөлбөр төлөвлөн боловсруулах, уг хөтөлбөрөөр хичээл заах, түүнийгээ үнэлж сайжруулах ажил болох нь ямар ч тайлбаргүйгээр ойлгогдож байна.

Өөрөөр хэлбэл “Сургалтын нэгж ажил” хэмээх нэр томьёо нь ажлын норм тогтоох, цалин хөлс тооцож олгох асуудалтай уялдан гарч ирсэн бөгөөд энэ нь багшийн ажлын нормыг хэмжих хэмжигдэхүүн болохоос багшийн хийж хэрэгжүүлэх баримт бичиг биш гэдэг нь тодорхой байна.

Гэтэл үүнийг 5 цаг үзэх 5 сэдвийг нийлүүлж нэг хөтөлбөр болгон төлөвлөх юм байна хэмээн эндүүрч, хүчээр 5 цагийн хичээлийг нэгтгэн төлөвлөсөн нэртэй хэсэг хүснэгт зуруулах болсон нь туйлын харамсалтай.

Энэхүү ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын төлөвлөлт, үнэлгээтэй уялдан 2007 оноос гарч ирсэн “Сургалтын нэгж ажил” хэмээх нэр томъёо, цаашдын эрх зүйн актуудаар баталгаажих болжээ. Сургалтын нэгж ажлын талаар гарсан хоёр дахь эрх зүйн акт бол 2007 оны 11 сарын 08-ны өдрийн БСШУ-ны сайдын “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг төлөвлөж, үнэлэх түр аргачлал” батлах тухай 416 дугаар тушаал юм.

Энэ тушаалын хавсралт болох түр аргачлалын 7-д “Стандартыг хэрэгжүүлэх багшийн ажлыг үнэлэхдээ бага, дунд боловсролын чанарын баталгааг тодорхойлсон боловсролын стандартын шаардлагыг хангахуйцаар сургалтын дидактик нэгжийг томсгосон сургалтын нэгж ажлаар хэмжинэ. Сургалтын нэгж ажлыг сургалтын төлөвлөгөөний 5 цагаар дундажлан тооцно”.

8-д “Сургалтын нэгж ажлын тоо нь багшийн боловсруулж хэрэгжүүлэх нэгж хичээлийн хөтөлбөрийн тоог тогтоох үндэслэл болно” (Боловсролын мэдээлэл, 2008) гэжээ.

Энэ тушаалд “Сургалтын нэгж ажил” гэсэн нэр томъёонд “сургалтын дидактик нэгжийг томсгосон” гэсэн үл тохирох ойлгомжгүй тодотгол хэрэглэсэн нь төөрөгдөл гүнзгийрэх нэгэн шалтгаан болсон бололтой.

Учир нь ... Дидактик нэгжийг томсгох гэсэн ухагдахууныг ерөнхий байдлаар: “Өөр хоорондоо ижил төстэй (төрөл) эсвэл эсрэг тэсрэг ялгаатай гэхээр онолын мэдлэг тэдгээрийг эзэмшихэд (бүтээхэд) тохирсон ерөнхий арга барилыг дотоод гүний нэгдлийн үүднээс авч үзэж иж бүрдэл болгон судлах үйл явц гэж ойлгож болно” (Р.Магсар, 2009. Т. 30), мөн “Дидактик нэгжийг тогтолцооны шинжилгээний зарчмаар томсгоно гэдэг нь өөр хоорондоо ижил төстэй эсвэл эсрэг тэсрэг гэхээр салангид тусгаар мэт олон мэдлэгийг дотоод гүний нэгдлийн үүднээс танин барьж нэгтгэн, цаг хугацааны хийгээд орон зайн хувьд нэгдмэл байдлаар авч үзэж судлахыг хэлнэ” (Э.Болормаа, 2009. Т. 52) гэсэн байдаг.

Эндээс дидактик нэгжийг томсгоно гэдэг нь өөр хоорондоо ижил төстэй, эсвэл эсрэг тэсрэг зүйлсийг нэгтгэн бүлэглэж авч үзэхийг хэлдэг ажээ. Энэ ойлголтонд тулгуурлан ...сургалтын дидактик нэгжийг томсгосон сургалтын нэгж ажлаар хэмжинэ. Сургалтын нэгж ажлыг

сургалтын төлөвлөгөөний 5 цагаар дундажлан тооцно гэсэн заалтыг эргэцүүлж үзэлгүй 5 цагийн хичээлийг нэгтгэх замаар дидактик нэгжийг томсгон заана хэмээн эндүүрсэн бололтой.

Уг нь ... сургалтын дидактик нэгжийг томсгосон сургалтын нэгж ажил гэсэн болохоос дидактик нэгжийг томсгосон сургалтын хөтөлбөр гэсэн зүйл ерөөс байхгүй байгааг анхаарууштай байна. Мөн тэрхүү нэгж ажил нь стандартыг хэрэгжүүлэх багшийн ажлыг үнэлэх хэмжүүр гэдгийг дахин тэмдэглэсэн байна. Стандартыг хэрэгжүүлэх багшийн ажил нь хөтөлбөрөө төлөвлөн боловсруулах, уг хөтөлбөрөөр хичээл заах, түүнийгээ үнэлж сайжруулах цогц үйл ажиллагаа билээ.

Мөн “Сургалтын нэгж ажлын тоо нь багшийн боловсруулж хэрэгжүүлэх нэгж хичээлийн хөтөлбөрийн тоог тогтоох үндэслэл болно” гэсэн заалтыг ч буруу зөрүү ухаарсан бололтой. Энэ заалт нь багш 7 хоногт 19 цагийн хичээл заах нормтой тул нэг нэгж ажил нь сургалтын төлөвлөгөөний 5 цагаар дундажлан тооцож үзвэл 3-4 нэгж ажил буюу дунджаар 15-20 ээлжит хичээлийн төлөвлөгөө бичнэ гэдгийг л тодотгосон мэт.

Үүний зэрэгцээ 2007 оны 11 сарын 08-ны өдрийн БСШУ-ны сайдын “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг төлөвлөж, үнэлэх түр аргачлал” батлах тухай 416 дугаар тушаалын хавсралтад нэгж хичээлийн хөтөлбөр гэсэн нэр томъёо санаатай хийгээд санамсаргүйгээр хэрэглэсэн нь “нэгж хичээл”, “нэгж хичээлийн хөтөлбөр” гэж байх юм байна гэсэн төөрөгдөл улам гүнзгийрэх эх үндэс болсон бололтой.

Энэхүү төөрөгдөл нь уг тушаал Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг төлөвлөж, үнэлэх асуудалтай холбоотой бөгөөд багшийн хийж хэрэгжүүлэх баримт бичиг биш гэдгийг эргэцүүлэлгүй шинэ нэр томъёонд хөтлөгдсөнтэй холбоотой мэт.

Энэ чиглэлээр гарсан гурав дахь эрх зүйн акт бол 2008 оны 12-р сарын 10-ны өдөр гарсан Монгол улсын Засгийн газрын “Улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгох тухай” 54-р тогтоол юм. Энэ тогтоолын хавсралтаар “Төрийн өмчит ЕБС, хүүхдийн цэцэрлэгийн багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшил олгох журам” батлагдаж 2009 оны 1-р сарын 1-ний өдрөөс мөрджээ.

Журмын 2.1.1-д Сургалтын байгууллагын багшид улирлын урамшил олгохдоо дараах шалгуур баримтална гээд улмаар 2.1.1.1-д “Нэгж хичээлийн хөтөлбөрийн төлөвлөлт,

боловсруулалт” хэмээн заасан. Ингэснээр “Нэгж хичээлийн хөтөлбөр” гэсэн шинэ ойлголт батжиж, улирлын мөнгөн урамшил авахын тулд ойлгосон ч, эс ойлгосон ч таван цаг заах хичээлийг нэг хүснэгтэд багтаасан “Нэгж хичээлийн хөтөлбөр” гэгч зүйлийг хийх болсон.

Энэхүү нэгж хичээлийн хөтөлбөрийн хамгийн сонирхолтой нь хөтөлбөрийг хийхдээ 5 удаа буюу 5 цаг заах, 5 сэдвийг 1 удаа заахаар нэгтгэж төлөвлөх бөгөөд заахдаа 5 салгаж заадагт оршино. Эндээс 5 удаа 5 салгаж заадаг юм бол нэгтгэж төлөвлөдгийн учир юу вэ? гэсэн асуулт зүй ёсоор дэвшинэ. Энэ нь 5 цагийн хичээлийг нэгтгэж төлөвлөснийг “Нэгж хичээл” хэмээн буруу ойлгосонтой холбоотой биз ээ.

Дидактик нэгжийг томсгох талаар “Монголын бага боловсролын математикийн сургалтад дидактик нэгжийг томсгох технологийг нэвтрүүлэх арга зүй” сэдвээр судалгаа хийсэн доктор Ц.Нямжав “Дидактик нэгжийг томсгох технологийг сургалтад нэвтрүүлснээр үзэх материалыг судлах цагийг 20% хүртэл хэмнэж, хэмнэсэн цагийг хоцрогдсон сурагчтай ганцаарчлан ажиллах болон суралцагчдын мэдлэгийг аль нэг чиглэлээр өргөтгөх боломжтой гэсэн дүгнэлтэд хүрсэн” (Ц.Нямжав, 2005, т.109) байна. Эндээс нэгэнт дидактик нэгжийг томсгон төлөвлөсөн бол түүнийхээ дагуу зааж цаг хэмнэх учиртайг, мөн дидактик нэгжийг боломжит сэдвүүдээр томсгон хэрэглэж болохоос байнга, дараалсан 5 сэдвийг нийлүүлж төлөвлөдөг механик зүйл биш болох нь ойлгогдож байна.

Ийнхүү анх 2007 онд гарсан “Сургалтын нэгж ажил” хэмээх нэр томъёо 2009 оноос “Нэгж хичээлийн хөтөлбөр” хэмээн нэрийн хувьд төдийгүй, агуулгын хувьд үндсээрээ өөрчлөгдөж төөрөгдөл төлөвшин тогтох нөхцөлийг бүрдүүлжээ.

Энэ асуудлаар гарсан дөрөв дэх эрх зүйн баримт бичиг бол 2009 оны 12-р сарын 14-ний өдөр БСШУ-ны сайдын “Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл батлах тухай” 561-р тушаал юм. Уг тушаалыг 2010 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэн мөрджээ. Энэ тушаалын хавсралтаар батлагдсан чиглэлийн 2.6-д Багшийн стандарт хэрэгжүүлэх ажлыг “Сургалтын нэгж ажил”-аар тооцож төлөвлөнө.

2.7-д Сургалтын нэгж ажлын агуулга ба хэмжээг бага, дунд боловсролын стандартыг хангахуйцаар сургалтын дидактик нэгжийг томсгосон тухайн курс хичээлийн нэгж хичээлийн хөтөлбөрийн агуулга ба тоогоор тодорхойлно.

2.8-д Нэгж хичээлийн хөтөлбөрийг

ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөний 5 цагаар дундажлан тооцож боловсруулна гэжээ.

Энэ удаа өмнөх актуудад гарсан “Сургалтын нэгж ажил”, “Нэгж хичээлийн хөтөлбөр” гэсэн нэр томъёо холилдон хэрэглэгдэх болсон байна.

Гэхдээ энд нягтлан үзвээс “Сургалтын нэгж ажил” гэдэг нь багшийн стандарт хэрэгжүүлэх ажлыг тооцох нэгж гэсэн сургалтын нэгж ажил гэж юу болох талаарх анхны тодорхойлолт хэвээр байна. Гагцхүү сургалтын нэгж ажлын агуулга ба хэмжээг ... сургалтын дидактик нэгжийг томсгосон тухайн курс хичээлийн нэгж хичээлийн хөтөлбөрийн агуулга ба тоогоор тодорхойлно гэсэн нь төөрөгдөл хадгалагдах үндэс болсон бололтой.

Энэхүү 2009 оны 12-р сарын 14-ний өдөр БСШУ-ны сайдын “Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл батлах тухай” 561-р тушаал нь бидний өгүүлэн буй “Сургалтын нэгж ажил”, “Нэгж хичээлийн хөтөлбөр”-ийн талаар гарсан сүүлчийн эрх зүйн акт бололтой. Бид энэ асуудлаар үүнээс хойш гарсан эрх зүйн акт олж үзсэнгүй.

Уг асуудлаарх сүүлчийн эрх зүйн акт болох БСШУ-ны сайдын 561-р тушаал 2013 оны 8 сарын 13-ны өдрийн БШУ-ны сайдын “Журам батлах” тухай А/293-р тушаалын 4-р заалтаар хүчингүй болсон байна.

Ийнхүү төөрөлдсөн эрх зүйн акт хүчингүй болсон атал, төөрөгдөл үргэлжлэн “Нэгж хичээлийн хөтөлбөр” хэмээх зохиомол зүйлийг хийлгэсээр, хийсээр буй нь нэн харамсалтай байна. Түүнчлэн 2013 оны 8 сарын 13-ны өдрийн БШУ-ны сайдын “Журам батлах” тухай А/293 дугаар тушаалын 1-р хавсралтаар “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-ыг баталжээ. Энэ журмыг 2014 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж буй билээ. Уг журмын 4.1-д зааснаар багшийн ажлыг 1. Төлөвшил, 2. Хүүхэд нэг бүрийн эзэмшсэн мэдлэг, чадварын ахиц, амжилт, 3. Авьяасыг нээн хөгжүүлсэн байдал, 4. Боловсролын үйлчилгээний сэтгэл ханамж, 5. Эрүүл мэндийн байдал гэсэн нийтлэг үзүүлэлтээр үнэлэх болсон. Иймд “Нэгж хичээлийн хөтөлбөр” хэмээх зохиомол зүйл нэг нь шаардаж, нөгөө нь хийхээ болимоор юм даа.

Эцэст нь яагаад манай ерөнхий боловсролын сургуулийн олон мянган багш нар бүгдээрээ ямар нэгэн тайлбар, эсэргүүцэлгүйгээр “Нэгж хичээлийн хөтөлбөр” хэмээх хийхэд ойлгомжгүй, түвэгтэй атлаа хэрэглэх боломжгүй, цаг, цаас

гарзадсан зохиомол зүйлийг сүүлийн 7-8 жилийн турш үг дуугүй хийсээр байна вэ? гэсэн асуулт анхаарал татаж байна. Энд олон нөхцөл, шалтгаан байдаг биз ээ.

Энэ нь бидний үзэж буйгаар дараах шалтгаантай бололтой. Үүнд: Юуны өмнө манай багш нар эрх зүйн мэдлэг боловсрол муутай, бие дааж холбогдох эрх зүйн актуудыг үзэж судалдаггүйтэй холбоотой. Өөрөөр хэлбэл өөрсдийнхөө хийж буй зүйлийг эрх зүйн үндэстэй эсэхийг мэдэх байтугай боддоггүй мэт. Хоёрдугаарт, өөрсдийн бие даасан, бүтээлч санаачлаг дутмаг, дээрээс ирсэн зааврын зөв, бурууг үл анзаарч сохроор дагадаг, бүхнийг бусдын хэлснээр үг дуугүй гүйцэтгэдэг өнгөрсөн нийгмийн үеийн сэтгэлгээний хоцрогдол, хүлцэнгүй байдал хэвээр байгаагай холбоотой мэт. Учир нь өнгөрсөн хугацаанд бидний мэдэхээр “Нэгж хичээлийн хөтөлбөр” гэгчийг эсэргүүцсэн санал гомдол нэг ч гараагүйн гадна, энэ бол зохиомол зүйл шүү, та нар ийм дэмий зүйл хийх шаардлагагүй, үүнийгээ болиоч гэхэд сургалтын менежер хий гэсэн, хийж байж цалин урамшууллаа авна гэсэн гомдмоор хариу хэлдэг байв. Товчдоо та нар төөрсөн байна гэдгийг нь хэлсээр байтал зам заасан хүнд үл итгэж, санаатай хийгээд санамсаргүйгээр буруу замаар будиулсан хүмүүст итгэн дагаж давхисан мэт.

Гуравдугаарт, төөрөгдүүлэгч гол субъект нь эхний ээлжид тухайн үеийн (2007) боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, тэдгээрийн түшмэдүүд, удаад нь сургуулийн удирдах ажилтнууд болно. Учир нь “Сургалтын нэгж ажлыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан аргачлалын дагуу тооцож үзнэ” (Боловсролын салбарын эрх зүйн, 2012, т. 33) гэсэн атлаа тэрхүү аргачлалаа гаргаагүй, улмаар дараа дараагийн эрх зүйн актууддаа “нэгж ажил” хэмээх нэр томъёогоо “нэгж хичээл”, “нэгж хичээлийн хөтөлбөр” гэсэн өөр өөр нэр томъёогоор өргөжүүлсэн байна.

Түүнчлэн Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын аргачлал гараагүй атал боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагуудаас төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан эрх зүйн актыг ойлгоогүй хэрнээ, ойлгосон дүр эсгэж түүнийг хэрэгжүүлэх талаар буруу удирдамж чиглэл өгсөн. Тэрхүү эрх зүйн үндэслэлгүй, буруу удирдамжийг сургуулийн сургалтын менежерүүд шууд хүлээн авч багш нарыг цалин мөнгөтэй нь холбон, захиргаадан хийлгэх болсон билээ. Үүнийг “Нэгж

хичээлийн хөтөлбөр” хэмээх зохиомол зүйл зовон зүдэн хийж буй багш нараас яагаад ийм хэрэггүй зүйл хийж байна вэ? гэхэд сургуулийн захиргаа, сургалтын менежер л хий гэсэн гэсэн хариу өгдөг. Сургалтын менежерүүдээс яагаад багш нараар ийм хэрэггүй зүйл хийлгээд байна вэ? гэхээр дээрээс л ийм удирдамж өгсөн шүү дээ гэсэн тайлбарууд батална. Улмаар тэрхүү алдаагаа өнөө хүртэл эргэж харахгүй, холбогдох эрх зүйн акт нь хүчингүй болчихсон байхад төөрөгдүүлээ үргэлжлүүлсээр байгаа нь нэн харамсалтай.

ДҮГНЭЛТ

Сургалтын онолд ч, практикт ч “Нэгж хичээл” гэсэн ойлголт байхгүй. Иймээс “Нэгж хичээлийн хөтөлбөр” гэж байхгүй нь ойлгомжтой болно. Бид “... Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын норм тогтоох, ... цалин хөлсийг тооцож олгох журам батлах тухай” эрх зүйн актын заалтыг буруу ойлгосны улмаас сургалтын онол, практикт байхгүй зүйлийг зохион, зохиомол зүйлийг зовон зовон хийж ирсэн байна.

Иймд энэ цаг мөчөөс эхлэн “Нэгж хичээлийн хөтөлбөр” хэмээх өөрийгөө болон өрөөл бусдыг хуурсан зохиомол зүйлийг хамгийн үнэт капитал болох цагаа үрэн үрэн, цаас гарздаж хийхээ больё. Үүнийг шаардаж шахан хийлгэдэг сургуулийн сургалтын менежер болон бусад албан тушаалтнууд алдаагаа ухаарч засаж залруулах шаардлагатай байна.

1. “Нэгж хичээлийн хөтөлбөр” хэмээх нэр томъёо орсон сүүлчийн эрх зүйн акт болох 2009 оны 12-р сарын 14-ний өдөр БСШУ-ны сайдын “Багшийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэхэд баримтлах чиглэл батлах тухай” 561-р тушаал хүчингүй болсон. Өнөөдөр багш нарын ажлыг 2013 оны 8 сарын 13-ны өдрийн БШУ-ны сайдын “Журам батлах” тухай А/293-р тушаалын 1-р хавсралтаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг үнэлэх, дүгнэх журам”-аар үнэлж буй бөгөөд энд “Нэгж хичээлийн хөтөлбөр” байтугай, “Нэгж ажил” гэсэн ойлголт ч байхгүй болсон.
2. ЕБС-ийн багш нар хичээл сургалтынхаа хэвийн үйл ажиллагааг хангах, улмаар чанар, үр өгөөжийг нь дээшлүүлэхийн тулд өөрийн заах хичээлийн сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө гэсэн үндсэн хоёр баримт бичгийг заавал хийж хэрэглэвэл зохино. Учир нь эдгээр баримт бичгүүдийг заавал хийж хэрэгжүүлэх эрх зүйн акт хүчинтэй хэвээр байна.

- Нөгөө талаас багш нарын сургалтын үйл ажиллагаанд зайлшгүй хэрэгтэй баримт бичгүүд юм. Иймд сургалтын менежерүүд энэ цаг мөчөөс эхлэн 1987 оны АБЯ-ны сайдын 358 дугаар тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн багш нараас сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө хийх зөвлөмж”-ийг сэргээн судалж түүнийг мөрдөн ажиллавал зохино.
3. Сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө нь аргазүйн материал, багшийн хөтлөх баримт бичиг, бүтээл бөгөөд тухайн багшийн заасан хичээлийн цагийг тооцох санхүүгийн баримт биш гэдгийг уг баримт бичгүүдийг хийж буй багш нар ч, хийлгэж буй сургуулийн удирдах ажилтнууд ч ухаарч, энэ онцгоос хандвал зохино.
 4. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон эрдэм шинжилгээ, аргазүйн байгууллагууд ерөнхий боловсролын сургуулийн журналаас эхлээд бусад баримт бичгүүдэд буй “Нэгж хичээл”, “Нэгж хичээлийн хөтөлбөр” гэх зохиомол нэр томъёогоо эргэн харж засч залруулах замаар өөрсдөө төөрөгдлөөс гарч, өрөөл бусдыг төөрөлдүүлэх ажлаа дуусгах цаг болжээ.
 5. Багш бэлтгэх сургуулийн сурган хүмүүжүүлэх ухаан, мэргэжлийн дидактикийн багш нар “Буруу замаар будаа тээж яваа” хүмүүсийг дагаж багш мэргэжлээр суралцаж буй оюутнуудаар “Нэгж хичээлийн хөтөлбөр” хэмээх хаана ч хэрэглэхгүй зохиомол зүйл хийлгэдгээ больж, ирээдүйн ажилд нь тустай Сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө хийлгэвээс зохино.
 6. Багш бэлтгэх сургуулиуд сургалт, дадлагатай холбоотой бичиг баримтуудаа эргэн харж “Нэгж хичээлийн хөтөлбөр” гэх зохиомол зүйл хийлгэхээр тусгасан бол засаж залруулах, хойшид гаргах баримт бичгүүддээ тийм зүйл тусгахгүй байх талаар анхаарах шаардлагатай байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Энхбаяр, Д. (1996-2012). *Боловсролын салбарын эрх зүйн баримт бичгийн эмхтгэл*. Улаанбаатар
Боловсрол Шинжлэх Ухааны Яам. (2007). 2007 оны 11 сарын 08-ны өдрийн БСШУ-ны сайдын “Ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлыг төлөвлөж,

үнэлэх түр аргачлал” батлах тухай 416 дугаар тушаал. *Боловсролын мэдээлэл*. 2008 оны 4 дүгээр сар, № 4 (91). Улаанбаатар

Болормаа, Э. (2009). Киррикулим тогтолцооны инвариант загварыг боловсролын хэрэгцээний онцлогт нийцүүлэн тусгайлах арга зүй. (Анагаахын хими боловсролын жишээн дээр). Улаанбаатар

Ардын Боловсролын Яам. (1988). Ерөнхий боловсролын сургуулийн багш нараас сэдэвчилсэн ба ээлжит хичээлийн төлөвлөгөө хийх зөвлөмж. *Сурган хүмүүжүүлэгч*, № 2. тал 9-11. Улаанбаатар

Магсар, Р. (2009). Суралцагчдад математикийн боловсролын цогц чадамж төлөвшүүлэх шинэ арга зүй. (6 дугаар ангийн математикийн жишээн дээр). Боловсрол судлалын докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол. УБ., 2009.

Нямжав, Ц. (2005). Монголын бага боловсролын математикийн сургалтанд дидактик нэгжийг томсгох технологийг нэвтрүүлэх арга зүй. *Боловсрол судлалын докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол*. Улаанбаатар

"Түүх нийгмийн ухааны сургуулийн боловсролын онол, аргазүйн асуудал" эмхэтгэл. 2016